

ДЕРЕК ПРИНС

ТӨР
ЗАСГИЙНХАА
ТӨЛӨӨ
ЗАЛБИРЪЯ

Улс үндэстнийхээ төлөө
бөгөөд удирдагч нарынхаа
төлөө үр дүнтэй залбирахуй

 maranata

ДЕРЕК ПРИНС

ТӨР ЗАСГИЙНХАА ТӨЛӨӨ ЗАЛБИРЬЯ: Улс үндэстнийхээ
төлөө бөгөөд удирдагч нарынхаа төлөө үр дүнтэй залбирахуй

Зохиогчийн зөвшөөрлийн дагуу МАРАНАТА бүтээв.

© 1970 Дерек Принс

© 2019 МАРАНАТА

www.maranata.mn

www.DerekPrince.mn

Библийн ишлэлийг

© 2004, 2011, 2013 Ариун Библиэс

Ариун Бичээс Нийгэмлэг

Энэхүү цахим номыг танд МАРАНАТА үнэ төлбөргүй хүргэж
байна. Та найз нөхөддөө цахим хэлбэрээр дамжуулж, дэлгэрүүлж
болно.

“... нэрээр минь дуудагдсан Миний
хүмүүс өөрсдийгөө даруу байлган
залбирч, нүүрийг минь эрэлхийлж,
хорон муу замуудаасаа эргэх аваас,
Би тэнгэрээс сонсож, тэдний нүглийг
уучлан, тэдний газар нутгийг эдгээнэ.”

2Шастир 7:14

Төр засгийнхаа төлөө залбиръя

*Чуулганы “Газрын давс байх” үйл
ажиллагаа - бидний газар нутгийг
эдгээх Бурханы амлалт - Бурханы
дөрвөн болзол - Сайн засаглалын төлөө
залбирах бидний үүрэг хариуцлага
- Сүнсний талбарт нөлөөлөхүй
шийдвэрлэх оролцоо - Цоорхой дээр
хэн зогсох вэ?*

Чуулган даян дэлхий дээр эрх мэдлээ олон арга замаар өсгөн нэмэгдүүлж чадна. Тэгвэл би өөрийн зүгээс та бүхэнд дөрвөн арга замыг санал болгож байна: залбирах, гэрчлэх, номлох, сайн үйлс. Эдгээр арга замаар чуулган газар дээр нэр нөлөөгөө хэрэгжүүлэх нь Бурханы хүсэл болой.

Чуулган залбирлаар дамжуулан дэлхийн үйл хэрэгт удирдах нөлөө үзүүлэхийг

Бурхан хүсдэг. Бичээс ч үүнийг тодорхой хэлдэг. Чуулган ингэж чадахгүй бол, амтаа алдсан давснаас өөрцгүй болно.

2Шастир 7:14 дээр: “нэрээр минь дуудагдсан Миний хүмүүс өөрсдийгөө даруу байлган залбирч, нүүрийг минь эрэлхийлж, хорон муу замуудаасаа эргэх аваас, Би тэнгэрээс сонсож, тэдний нүглийг уучлан, тэдний газар нутгийг эдгээнэ” гэжээ. Энэ бол Эзэнд зориулж барьсан өргөөгөө даатгасны дараа Бурханаас Соломонд өгсөн илчлэл юм. “За, тийм ээ. Энэ чинь өнө эрт Хуучин гэрээний цагт Соломонд өгсөн амлалт. Өнөөгийн бидэнд ямар хамаатай?” хэмээн эгдүүцэх хүн та нарын дунд байгаа л байх. Тэгвэл би товч бөгөөд тодорхой хариулья.

2Коринт 1:20: “Учир нь Бурханы бүх амлалт Түүний дотор “За” ажээ. Тиймд бид Бурханы алдрын тулд Түүгээр дамжуулан “Амень” гэдэг.” *Зарим* нэг амлалт бус, харин бүх амлалт! *Өнгөрсөнд* за бөгөөд амень байсан бус, харин яг *одоо* за бөгөөд амень байна. Зөвхөн *за* бус, харин Бурханы алдрын төлөө Түүгээр дамжуулан *за бөгөөд*

амень гэдэгт та эргэлзэх хэрэггүй. “Бид” гэдэг нь Христэд итгэдэг бүх хүнийг буюу та, бид хоёрыг хэлсэн хэрэг. Бид Бурханыг хэрхэн алдаршуулах вэ? Түүний амлалтыг тунхагласнаараа! Бурханы амлалтыг тунхаглах тусам, Бурханыг алдаршуулна. Бурханы бүх амлалт Христийн дотор өнөөдөр бидэнд боломжтой.

2Шастир 7:14-ээр эшлэлийг дахин гаргаад, энэ амлалт өнөөгийн та, бид хоёрт хамаатай болохыг одоо та ойлгосон гэдэгт би итгэж байна! Бурхан “нэрээр минь дуудагдсан Миний хүмүүс” гэжээ. Энэ нь Кинг Жэймс Вержн Библийн хувилбар юм. Тэгвэл Еврей эх бичвэр дээрээ “Миний нэрээр дуудуулдаг хүмүүс” гэдэг. Бурханы нэрээр дуудуулдаг хүмүүс нь Бурханы хүмүүс ажээ. Та Христэд итгэгч гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ нь та Христийн нэрийг тээж, Түүний нэрээр дуудуулдаг гэсэн үг. Та Христийн нэртэй холбоотой болжээ. Та Христийн нэрээр Христэд итгэдэг хүн хэмээн тодорхойлуулах болжээ. Тиймээс энэ амлалт нь Христэд итгэдэг хүмүүст

буюу Христийн нэрээр дуудуулдаг хүмүүст хамаатай ажээ.

Хүмүүс нь дөрвөн зүйлийг үйлдбэл, Бурхан гурван зүйлийг үйлдэхээ амлажээ. Бурхан үйлдэхээр амласан гурван зүйлээ хийхээс өмнө Бурханы хүмүүс дөрвөн зүйлийг үйлдэх ёстой аж. Энэ бол болзолтой амлалт. Бурхан “Миний хүмүүс Миний болзлыг биелүүлэх юм бол, дараа нь Би эдгээрийг үйлдэнэ” гэснээс биш, “Би зүгээр хийгээд өгнө” гэж хэлээгүй байна.

Эхний эшлэлийн төгсгөлийг харах юм бол, Бурханы хүмүүстээ хийж өгнө гэж амласан сүүлийн зүйл нь газар нутгийг нь эдгээх амлалт ажээ. Энд бидний аж төрж байгаа энэ газар нутгийн талаар өгүүлсэн нь тодорхой байна. Аж төрж байгаа газар нутгаа Бурханаар эдгээлгэхийн төлөө хийх ёстой зүйлийг үйлдэх хүч нь Түүний хүмүүст байдгийг Бурхан айлджээ. Эх орноо нэг хар даа. Эдгэрэл хэрэгтэй байна уу? Үүнд “*Хэрэгтэй!*” гэсэн ганц л хариулт өгнө. Газар нутагт маань эдгэрэл хэрэгтэй гэдэг баримт нь Бурханы хүмүүс

Бурханы хийгээрэй гэсэн зүйлийг хийлгүй, хөсөрдүүлснийг л илтгэнэ! Энэ хариуцлага хар тамхичин, янхан юмуу чуулганы үүдийг татаж үзээгүй хүн *дээр бус*, харин бидэн дээр байна. Үүнд Христийн нэрээр дуудуулдаг хүмүүс - бид хариуцлагатай.

Газар нутаг маань эдгэрээгүй байгаа бол, үүнд ганц л шалтгаан бий. Бид Бурханы шаардсан юмсыг хийгээгүй ажээ. Энэ бол чухам үнэн гэдэгт би итгэдэг. Энэ нь Матай 5:13 дээр “Та нар газрын давс. Хэрэв давс амтаа алдвал хэрхэн буцааж давслаг болгох вэ? Энэ нь гадагш хаягдаж, хүмүүсийн хөл дор гишгэгдэхээс өөр юунд ч хэрэг болохгүй” хэмээн Есүсийн айлдсан үгийн өөр нэг хувилбар юм. Бидний ачаар газар нутаг маань эдгэрээгүй байгаа бол, давс маань амтаа алджээ гэсэн үг.

Давс яадаг билээ? Нэгдүгээрт - амт оруулдаг. Бид газар дээр амьдарч байгаа цагтаа Бурханы мэлмийд газрын амт лугаа адил байдаг. Өөрөөр хэлбэл, Христэд итгэдэг хүмүүсийн улмаас л Бурхан дэлхийг хүлээн авдаг. Бид байгаа учраас л Бурхан

дэлхийд хилэгнэж, шүүлгүй, нигүүлсэнгүй, өршөөнгүй ханддаг.

Би өөрийгөө очсон газар бүрийдээ өөрчлөлт авчирдаг гэдэгт итгэдэг. Үүнийг тухайлбал Дэлхийн II дайны цагаар мэдэж авсан билээ. Миний байгаа газар бусад цэргүүд аюулгүй байдаг байв. Үүнийг ч аврагдаагүй цэргүүд мэддэг байлаа. Хойд Африкийн цөлийн хуурай мухарт байхад, итгэдэггүй цэргүүд надад хандан: “Байлдагч Принс, чамайг бидний дэргэд байгаад баяртай байна” гэж хэлдэг байж билээ. Елиша Елиад юу гэж хэллээ? “Эцэг минь, эцэг минь, Израилийн тэрэг ба морьтон минь!” (2Хаад 2:12) гэж хэлдэг. Тэд хаана байлаа? Хаадын дэргэд биш, харин эш үзүүлэгч нарын дэргэд байсан.

Бид бол улсынхаа батлан хамгаалах болсон хүмүүс. Бид улс үндэстнүүдийн бамбай болсон хүмүүс. Содомын жишээг л хар. Абрахам Бурханд: “Арван зөвт хүн байвал, Та тэр хотыг өршөөх үү?” гэсэн. Бурхан: “Өршөөнө өө” л гэсэн. Тийм боловч арван зөвт хүн олдоогүй учраас, Бурхан тэр

хотыг өршөөж чадаагүй юм. Содомд хэдэн хүн байсныг би мэдэхгүй. Гэхдээ пропорц нь хүчин төгөлдөр хэрэгжинэ. Арван зөвт хүн Содомын дайтай хотыг аварч чадах ажээ. Тэгвэл зуун зөвт хүн Содомоос арав дахин том хотыг аварч чадах нь байна. Мянган зөвт хүн Содомоос зуу дахин том хотыг аварч чадах нь байна. Гэх мэтчилэн үргэлжилнэ. Чуулган явах үед энэ дэлхий яана даа гэж би зовнидог. Дэлхий давсгүй болно. Тэгээд эцэс төгсгөлгүй, хэмжээ хязгааргүй уур хилэн, шүүх цутгана. Харин бид энэ дэлхий дээр байгаа цагтаа газрын давс байсаар байна.

Давс мөн хамгаалах ач холбогдолтой. Ялзарч муудахаас сэргийлдэг. Хөргөгч гэдэг эд бүтээгдэхээс өмнө махыг муутгахгүй гэж давслан хадгалдаг байжээ. Бид юуны тулд энэ дэлхий дээр аж төрж байна? Завхралаас хамгаалахын төлөө. Ёс суртахууны, нийгмийн, улс төрийн - бүх төрлийн завхралаас. Бид энэ дэлхий дээр байгаа цагтаа үүнийг хийнэ. Есүс: “Хэрэв давс амтаа алдвал хэрхэн буцааж давслаг болгох вэ?”

Энэ нь гадагш хаягдаж, хүмүүсийн хөл дор гишгэгдэхээс өөр юунд ч хэрэг болохгүй” гэж хэлсэн. Чуулган дэлхийн давс байх үүргээ биелүүлж чадахаа болибол, гадагшаа хүний хөлд хаягдана. “Тэр хүн” нь коммунистууд эсвэл нацистууд эсвэл хараахан мэндлээгүй байгаа өөр ямар нэгэн “ист” - ууд байж болох. Гол нь тэд дэлхийн давс байх үүргээ биелүүлж чадаагүй чуулганыг уландаа гишгэлэх хүмүүс байх юм.

Тэгэхээр, Бурхан хүмүүсээсээ чухам юу шаардана вэ? Нэгдүгээрт - “...өөрсдийгөө даруу байлгах.” Энэ бол шашны хүмүүсийн хувьд хийхэд хамгийн хэцүү зүйл. Би үүнийг егөөдөж биш, үнэн голоосоо хэлж байна. Хүмүүс “Бурхан минь, намайг даруусгаач” гэдэг. Гэтэл Бурхан ингэж хэлээгүй. Бурхан “Өөрийгөө даруусга” гэснээс биш, “Би чамайг даруусгана” гэж хэлээгүй. Бурхан таныг даруусгаж чадахгүй. Бурхан таныг шившиглэж чадна. Магадгүй ингэх шаардлагатай ч байж мэдэх. Гэхдээ таныг даруу болгож чадах цорын ганц хүн бол та юм. Даруу зан нь таны хүслийн дотоод

үйлдэл болно. Өөрөөр төрөх боломжгүй. Та өөрийгөө даруусгах сонголт хийхгүй бол, амаараа шороо үмхсэн ч, тогос мэт гэдгэр хэвээрээ үлдэнэ.

Эхний болзол нь өөрийгөө даруусгаж, Бурханд захирагдах ажээ. Бурханд захирагдсан хүн Түүний Үгэнд ч, эрх мэдэлд ч захирагдана. Бурханд захирагддаг гэж хэлэх амархан ч, Бурханы Үг “Христээс эмээн нэг нь нөгөөдөө захирагд. Эхнэрүүд ээ, Эзэнд адил нөхрүүддээ захирагд. ...

Хүүхдүүд ээ, [Эзэн дотор] эцэг эхдээ дуулгавартай бай” (Ефес 5:21-22, 6:1) гэдэг. Үүн дээр л олон хүн бүдэрдэг. Олон хүн “Би Бурханд захирагддаг” гэдэг ч, бусадтай тогтоосон харилцааг нь шалгабал, тэс өөр дүр зураг харагдана.

Та өөрийгөө даруусгасан бол, үүнийг үйлдэл чинь харуулна. Үе үе Бурханы өмнө нүүрээрээ газар хэвтэж байхад гэмгүй шүү. Та ингэж үзсэн үү? “Бурхан минь, байх ёстой газраа байна! Би бол өт хорхой. Би шорооноос төрсөн хүн. Шороо бол миний байх газар” гэж хэл. Арай дэндэнэ ээ гэж үү?

Тэгвэл Библиэс Бурханы өмнө яг ийнхүү нүүрээрээ хөсөр хэвтэж байсан Абрахам, Мосе, Давид, Даниел тэргүүтэй хүмүүсийг олж үзээрэй. Тэгээд ч Бурханы өмнө нүүрээрээ хөсөр хэвтээгүй Бурханы аугаа зарц гэж бараг байхгүй шүү. Мосе, Давид, Даниел тэргүүтэй хүмүүс үүнээс ичээгүй байхад, таны нэр хүнд яав л гэж.

“Нэрээр минь дуудагдсан Миний хүмүүс өөрсдийгөө даруу байлган...” Энэ эхний алхмыг хэрхэвч орхигдуулж болохгүй. Бурхан сүнсний хөтөлбөрөө: 1, 2, 3, 4 гэсэн дөрвөн ангиар зохион байгуулжээ. Та 1-ээр ангиа дүүргэхээс нааш 2-аар анги руу дэвшихгүй. Та 1-ээр ангидаа арван жил улирсан ч хамаагүй, Бурхан таныг анги дэвшүүлэхгүй. Тиймээс л олон хүн нэг ангидаа гацчихдаг. “Эзэн минь, би 1-ээр ангиа бараагүй ч, 2-аар ангидаа хичээнэ. Энэ ангийг л алгасчихъя. Тэгвэл дараагийн ангиа дүүргэчихнэ” гэж бүү бод. Энэ чинь бүтэхгүй!

Хоёрдугаар алхам нь залбирал болно. “Нэрээр минь дуудагдсан Миний хүмүүс өөрсдийгөө даруу байлган, залбирч...”

Өөрийгөө даруусгаагүй байж бүү залбираарай. Залбирлын өмнө даруу байдал орно.

“... Залбирч, нүүрийг минь эрэлхийлж...”

Гуравдугаар алхам нь Бурханы царайг эрэн хайх юм. Энэ юу гэсэн үг вэ? Миний ойлгож байгаагаар, энэ нь ямар ч саад, тотгор байхгүй Аугаа хүчирхэг Бурханы шууд оршихуйд явж ороод, Аугаа хүчирхэг Бурхантай нүүр нүүрээ уулзалдах явдал болой. Та залбирлын цуглаанд очиж болох ч, залбирлын цуглаан нь Бурханы царайг эрэн хайх явдал биш юм.

Нэгэн залуу Ариун Сүнсний баптисм хүлээн авахаар надтай уулзав. Тэрбээр Чуулганы залуусын цуглааны ажилтан байлаа. Би түүнтэй Гурав дахь өдрийн орой уулзаж болно гэтэл, тэрбээр тэр орой залбирлын цуглаантай, заавал тэнд байх ёстой гэв. Тэгэхээр нь би: “Тэгвэл тохиромжгүй юм байна” гэтэл, залуу: “Яалаа гэж, харин ч тохиромжтой. Бид 20-21 цагийн хооронд залбирдаг” гэж билээ. Тэр бол залбирлын цаг болохоос биш, Бурханыг

эрэн хайсан явдал биш юм. Бурханыг эрэн хайж байгаа хүн Бурханы оршихуйд орон ортлоо хэзээ ч зогсдоггүй - шөнөжингөө болсон ч хамаагүй. Тэрбээр Бурхантай холбогдсон цагтаа л зогсоно.

Дөрөвдүгээр алхам нь: "...хорон муу замуудаасаа эргэх... ." Хэн? Архичид, чуулганд явдаггүй залуус уу? Үгүй ээ, *Бурханы хүмүүс - Христэд итгэдэг хүмүүс!* Сэргэлтийн саад нь чуулганы гадна бус, дотор л байдаг. Хэзээ ч гадна байгаагүй.

Шүүх хаанаас эхлэхийг та мэдэх үү? Бурханы өргөөнөөс. Петр "Учир нь шүүлт Бурханы гэр бүлээс эхлэх цаг нь болжээ" (1Петр 4:17) гэсэн. Үүнийг бүр тодорхой болгох үүднээс Петр "...энэ нь биднээс эхэлнэ" гэж хэлээд, араас нь "(Тэгвэл) Бурханы сайнмэдээнд дуулгаваргүйчүүдийн төгсгөл юу болох вэ?" гэжээ. Бурхан хэзээд ингэж л ажилладаг. Бурхан хамгийн сайн мэддэг хүмүүсээс л эхлэдэг. "Хэнд их өгөгдсөн байна, түүнээс ихийг шаардана. Хэнд их даалгагдсан байна, түүнээс ихийг нэхнэ" (Лук 12:48). Та: "Принс ах аа, надад

хорон муу зам байхгүй” гэж хэлж болох. Тэгвэл би: “Та Бурханд хангалттай ойртоогүй л байна даа. Бурханы оршихуйд орж үзсэн хүн өөрийнхөө хорон муу замыг хардаг. Хорон муу замгүй гэдэг чинь Бурханаас хол байгаагийн л шинж” гэж хариулна.

Энэ дөрвөн алхмын дараа Бурхан “Би тэнгэрээс сонсоно” гэжээ. Бурхан залбирал бүрийг сонсох албагүй. Та үүнийг мэдэх үү? Миний бодлоор, Чуулганд явдаг олон хүний залбирал таазнаасаа хэтэрдэггүй. Бурхан залбирал бүрийг сонсох албагүй. Үнэндээ Бурхан “Бид юу ч гуйсан, Тэр биднийг сонсоно гэдгийг бид мэдвэл, бид Түүнээс гуйснаа авсан болохоо мэднэ” (1Иохан 5:15) гэдэг. Бурхан *хариулахад* бус, Бурханд *залбирлаа сонсгоход* л гол бэрхшээл бий.

“...Би тэнгэрээс сонсож, тэдний нүглийг уучилна... .” Хэний нүглийг? Янхан, хар тамхичны нүглийг үү? Үгүй ээ, *чуулганы* нүглийг!

“...Тэдний газар нутгийг эдгээнэ.” Асуудал тодорхой байна. Газар нутаг эдгэрээгүй байгаа бол, үүнд Бурханы хүмүүс

л буруутай. Би энэ талаар их эргэцүүлж, залбирч, тунгаасан. Орчин цагийн Америкийн нөхцөл байдлын хариуцлага нь чуулганы босгон дээр хэвтэж байна. Би энэ үнэнд итгэдэг. Үүнд би ч хариуцлагатай. Таныг буруутгаад, өөрөө цэвэр үлдэх санаа надад алга.

Залбирлаар ирэх эдгэрэл

Эдгэрэл хэрхэн ирдэг вэ? Би танд залбирлын талаар ярьмаар байна. Энэ яриагаа 1Тимот 2-аар бүлгийн эхний дөрвөн эшлэл дээр тулгуурлан хийе:

1. Тиймээс бүх хүний төлөө гуйлт, залбирал, зуучлан залбирал хийгээд талархал өргө гэж юуны өмнө чамайг ятгая.
2. Хаад болон эрх мэдэлтэй бүхний төлөө залбир. Тэгвэл бид итгэл сүсэгтэй бас хүндлэлтэй, тогтуун, төвшин амьдрах болно.

3. Энэ нь бидний Аврагч Бурханы мэлмийд сайн бөгөөд нийцтэй.
4. Тэрээр бүх хүн аврагдаж, үнэний мэдлэгт ирээсэй гэж хүсдэг.

Эдгээр үгийг авч үзье.

Паул “Нэн тэргүүнд *залбир!*” гэжээ. Залбирлыг алгасах юм бол, ямар ч олон сайхан төлөвлөгөө, систем, хөтөлбөртэй байсан - эдгээрийгээ ажиллуулах хүчгүй байна. Яг л цахилгааны холболтыг нь хийсэн боловч, генератортай нь холбоогүй байшинтай адил. Тэнд ямар ч тог ирэхгүй. Цахилгааны холболтыг нь зөв зүйтэй хийсэн, чийдэн нь чанартай байсан ч, тог байхгүй учраас, юу ч асахгүй. Христийн чуулганы хүчдэл нь залбирал бөгөөд иймээс л Паул “Нэн тэргүүнд залбир!” гэжээ.

Тэгвэл Паул биднийг юуны төлөө залбир гэсэн? Нэгдүгээрт - хаад болон эрх мэдэлтэй бүхний төлөө залбир гэсэн. Миний мэдэхийн, Христэд итгэдгээ мэдэгддэг хүмүүсийн дийлэнх нь эрх баригчдынхаа төлөө *нэн*

тэргүүнд байтугай, ер нь залбирдаггүй.

Та Эпископал хүн бол, таны залбирлын номд эрх баригчдынхаа төлөө өргөх залбирал байгааг би баттай мэдэж байна. Тийм залбирал байгаа нь сайн хэрэг. Гэхдээ би Англикан байсан хүнийхээ хувьд өөрийнхөө туршлагаас танд бас өөр нэгэн зүйлийг хэлж чадна. Залбирал хэлэх болоод залбирах нь тэс ондоо зүйлс шүү. Эдгээр нь ижилхэн зүйлс биш. Олон хүн залбирлынхаа номоос эшлэж хэлдэг бөгөөд таван минутын дараа тэднээс юу залбирсныг нь асуухад, юу ч санадаггүй. Энэ бол хэлбэрдэлт.

Залбирлын эхний сэдэв нь юу вэ? “Ерөнхийлөгч, сенаторууд, төлөөлөгч нар, захирагч нар, хотын дарга нар, цагдаагийн дарга нар гэх зэрэг эрх баригч *бүх хүний* төлөө залбирах”. Та тэдний төлөө залбирдаг уу? Та ерөнхийлөгчийнхөө төлөө хэзээ хамгийн сүүлд залбирав? Та хамгийн сүүлд залбирсан уу, шүүмжилсэн үү? Эрх баригчдын төлөө залбирвал, шүүмжлэх чинь багасна. Бурхан таныг шүүмжлэлд биш, залбиралд дуудсан. Та залбирахгүй байвал,

дуулгаваргүй байна гэсэн үг. Би Англи хүн боловч, Америкийн ерөнхийлөгчийн төлөө өдөр бүр залбирдаг. Гэргий минь гэрчилнэ. Бид хамтдаа залбирдаг бөгөөд энэ аугаа улсын удирдагчийн төлөө залбираагүй өдрүүд ховор. Түүнд залбирал хэрэгтэй гэдгийг тэр өөрөө ч мэддэг гэдэгт би итгэлтэй байна. Танай ерөнхийлөгчид ч залбирал хэрэгтэйг тэрбээр мэдэж л байгаа.

Эрх баригчидтай холбогдуулан юуны төлөө залбирах уу? Энэ бол Библид хэлсэн хамгийн учир зүйтэй залбирал гэж би хэлнэ. Хоёрдугаар эшлэлийн хоёрдугаар хагаст “бид итгэл сүсэгтэй бас хүндлэлтэй, тогтуун, төвшин амьдрахын” төлөө залбир гэжээ. Товчхондоо “сайн засаглалын төлөө” залбир. Үүнтэй санал нийлж байгаа биз дээ? Бид сайн засаглалтай байж байж л итгэл сүсэгтэй бас хүндлэлтэй, тогтуун, төвшин амьдрах болно.

Гуравдугаар эшлэлд Паул: “Энэ нь бидний Аврагч Бурханы мэлмийд сайн бөгөөд нийцтэй” гэж байна. “Энэ нь” гэж юуг хэлнэ вэ? Өмнөх эшлэлд хэлснээр “бид

итгэл сүсэгтэй бас хүндлэлтэй, тогтуун, төвшин амьдрах” нь буюу товчхондоо “сайн засаглалтай байх” нь юм.

Бурхан яагаад амар тайван, эрэмбэ дараалал, сайн засаглалыг хүснэ вэ? Маш бодитой, практик шалтгаанаар тэр. Яагаад гэвэл Бурхан “бүх хүн аврагдаж, үнэний мэдлэгт ирээсэй гэж хүсдэг.” Ямар нөхцөл дор үнэнийг бүх хүнд авчрах амар вэ? Шударга, нэгдмэл, хууль, дүрэм, иргэний эрхийг сахидаг засаглал дор уу? Эсвэл хүчирхийлэл, эмх замбараагүй байдалтай тэмцдэггүй, нөхцөл байдлыг зохицуулдаггүй, шударга бус, дарангуйллын засаглал дор уу? Ямар засаглал үнэнийг бүх хүнд хүргэхэд амархан болгодог вэ? Сайн засаглал гэдгийг эрүүл ухаантай хүн бүр хэлэх байх. Тиймээс л Бурхан энэ эрин цагт Түүний гол зорилго болсон сайн мэдээг дэлгэрүүлэн дэмждэг сайн засаглалыг хүсдэг. Тийм газар бэрх, ээдрээтэй юмс үгүй бөгөөд бүх юм ойлгомжтой, боломжийн байдаг.

Би дахиад хэлье! Христэд итгэдэг хүмүүсийн хамгийн эхний ажил бол *залбирал*

болохыг Библи хэлдэг. Залбирлын хамгийн эхний сэдэв бол *эрх баригчид*. Тэдэнтэй холбогдуулан юуны төлөө залбирах уу? Бид бурханлаг, амар жимэр, амгалан амьдрахын төлөө. Яагаад үүний төлөө залбирах ёстой гэж? Яагаад гэвэл ийм амьдрал нь сайн мэдээг дэлгэрүүлдэг. Учир зүйг нь харж байна уу? Итгэж үнэмшиж байна уу? Надад бол тун ойлгомжтой байна. Энэ бол сансрын нууц биш. Үгийнхээ гэрлээр нууцуудыг гийгүүлж өгсөн Бурхандаа талархъя! Энэ бол энгийн, боломжийн, бодитой, бүтэмжтэй зүйл. Сайн засагтай байх нь Бурханы хүсэл гэдэгт би итгэдэг. Бусад улс, үндэстнийг түр хойш тавиад, ганцхан өөрийнхөө улс дээр төвлөрө л дөө. Монгол улс сайн засаглалтай байх нь Бурханы хүсэл мөнөөс мөн.

Бурханы хүслийн дагуу залбирвал, юу болно гэж Библи хэлсэн? 1Иохан 5:14-15 дээр “Бид Түүний хүслийн дагуу юу ч гуйсан, Тэр биднийг сонсдог нь Түүний өмнө бидэнд байгаа итгэл зориг юм. Бид юу ч гуйсан, Тэр биднийг сонсоно гэдгийг бид мэдвэл, бид Түүнээс гуйснаа авсан

болохоо мэднэ” гэдэг. Өөрөөр хэлбэл, та Бурханы хүслийн дагуу залбирч байгаагаа мэдэж байгаа бол, Бурханы өмнө хүсэлтээ өргөн барьснаа мэднэ. Бурхан энэ улсад сайн засаглалыг хүсдэг бөгөөд бид ч үүнийг нь мэдээд, үүний дагуу залбирсан бол, Бурхан биднийг сонсдог гэдгийг мэднэ. Бурхан биднийг сонсдог гэдгийг мэдбэл, хүссэн хүсэлтээ хүлээн авснаа мэднэ. Манай засаглал муу байгаа бол, шалтгаан нь юу вэ? Бурханы хүмүүс Бурханы болзлыг биелүүлээгүй, залбираагүй ажээ.

Товчхондоо, Христэд итгэдэг хүмүүс өөртөө тохирсон засаглалаа л хүртдэг. Мэдээж хүлээх хугацаа гэж бий. Юмс нүд ирмэхийн зуур өрнөхгүй. Тийм боловч ерөнхийд нь аваад үзбэл, дээр тогтсон засаглалынхаа төлөө Христэд итгэдэг хүмүүс л хариуцлагатай байдаг. Та багахан шиг шүүмжлээд, ахиухан шиг залбирвал, шүүмжлэх зүйл чинь багасна. Энэ бүхэнд бичээсийн, тодорхой шалтгаан бий. Яагаад Бурханы хүмүүс хариуцлагатай вэ? Яагаад гэвэл үр дүн бүтээж чадах цорын ганц

хүмүүс нь бид юм. “Учир нь бидний тэмцэл бол мах цусны эсрэг биш, харин энэхүү харанхуй ертөнцийн захирагчид, эрх мэдэл, хүчнүүд, тэнгэрлэг оршихуй дахь ёрын муу сүнслэг хүчний эсрэг билээ” (Ефес 6:12). Паул “Бид тэмцдэг (барилддаг)” гэж байна. Гэтэл зарим итгэгч “бидний тэмцэл... биш” гэсэн хэсгийг нь л тодруулж уншаад байдаг. Паул ингэж хэлээгүй. Паул “бид тэмцдэг (барилддаг) - гэхдээ мах цусны эсрэг биш” л гэж хэлсэн. Паул эртний Олимпийн тоглолтоор үлгэрлэн ярьжээ. Олимпийн тэмцээн дундаас бөх шиг хүнд спорт байгаагүй гэдэгтэй түүхчид санал нийлдэг. Тэгвэл бидний итгэлийн амьдралыг ч бөхийн барилдаантай зүйрлэбэл онох байх. Барилдаж буй бөх хүнд хөдөлгөөнд оролцдоггүй хэсэг байхгүй. Тамирчин хүний бүх эрхтэн, эд, эс оролцоно. Бид ч гэсэн барилдаж байна - гэхдээ мах цустай биш. Паул биднийг хүнтэй тэмцээгүй гэж хэлсэн.

Тэгвэл бид хэнтэй тэмцэнэ вэ?

- Энэхүү харанхуй ертөнцийн захирагчид - энгийнээр хэлбэл “энэ цагийн харанхуйллын захирагч нар,
- Эрх мэдэл - үл үзэгдэх хаанчлал,
- Хүчнүүд - эдгээр үз үзэгдэх хаанчлалын эзлэдэг эрх мэдлийн талбар,
- ёрын муу сүнс - энгийнээр хэлбэл муу ёрын сүнснүүдтэй тэмцэж байна.

Энэ тэмцэл хаана өрнөж байна? “Дээд газар” буюу “тэнгэрлэг газруудад.” Бурханы Үгийн энэ илчлэлийг Христэд итгэдэг хүн бүр мэдбээс зохилтой. Бурхантай, Бурханы бүхий зорилготой дайсагнадаг зохион байгуулалттай хаанчлал оршдог бөгөөд энэ нь Сатаны хаанчлал юм. Сатанд хаанчлал байдгийг Есүс хэлсэн. Үүгээр барахгүй, Сатан энэ хаанчлалаа бүрэн захирдгийг бас хэлсэн. Энэ нь Бурхантай бүрэн тэрсэлддэг, хуваагдалгүй хаанчлал юм.

Энэ хаанчлал нь “тэнгэрлэг газарт” оршино. Энэ нь Бурханы оршин байдаг “гурав дахь тэнгэр” ч биш, бидний дээрх

“нэг дэхь тэнгэр” ч биш, харин завсрын буюу хоёр дахь тэнгэр гэдэг дээр Библийн ихэнх тайлбарлагч нар санал нийлдэг. Энэ дэлхийн төвшнөөс дээгүүр орших нэгэн үл үзэгдэх хаанчлал бий бөгөөд тэр нь харанхуйн хаанчлал билээ. Энэ нь Бурханыг, Бурханы зорилгыг, Бурханы хүмүүсийг нэг нүдээрээ ч үздэггүй, жадлан эсэргүүцдэг хаанчлал юм. Тэр хүмүүсийнх нь тоонд та, бид хоёр ч багтана. Дьявол таныг нэг нүдээрээ ч үзэхгүй. Тэр таныг хорлож, хохироож, устгахын төлөө чадахаасаа чадахгүйгээ хүртэл явна. Тэр хулгайлж, алж, устгахын төлөө л ирдэг. Тэр бол тун хүчтэй нэгэн.

Тэгвэл энэ хаанчлалыг нураах нь Христэд итгэдэг бидний ажил. Үүнийг ерөнхийлөгч, генералууд хийж чадахгүй. Тэдэнд зохих зэвсэг нь байхгүй. Махан бие, цусан бодтой хийх дайн байсан бол бид танк, хуяг, онгоц хэрэглэхсэн. Гэтэл энэ дайн махан биетэй хийх дайн биш учраас, танк, хуягт, онгоц ямар ч нэмэргүй юм.

Энэ байдлыг улс төрийн олон удирдагч ухаарч эхлэжээ. Тэд яг ингэж ярихгүй ч,

ийм санааг илэрхийлдэг. Энэ улсын бараг бүх удирдагч шийдэж чадахгүй асуудалтай тулгарснаа хүлээн зөвшөөрч байгааг би л хувьдаа тодорхой хардаг. Библи ч үүнийг хэлдэг.

Энэ дайн махан бие, цусан бодтой хийдэг дайн биш юм. Та нацистуудыг алж болох ч, нацизмыг сөнөөхгүй. Та үй түмэн хүнийг цааш нь харуулсан ч, тэдний цаадах сүнсний хүчийг шийдвэрлэж чадахгүй. Хүн аллаа гээд асуудал шийдэгдэхгүй. 2Коринт 10:3-5 дээр Паул: “Учир нь бид махбодод алхдаг ч, махбодын дагуу дайтдаггүй” - бидний дайн махан биеийн талбарт өрнөөгүй, энэ нь махан биеийн талбар биш, энэ нь махан бие, цусны эсрэг дайн биш. “Бидний байлдааны зэвсэг нь махбодынх бус” - бөмбөг, буу, танк биш, “харин ялагдашгүйг ч (Сатаны бат цайзуудыг) ялж чадах Бурханы хүчит зэвсгүүд юм” гэжээ.

Бат цайзууд хаана байгааг тэмдэглэнэ үү! “Бурханы мэдлэгийн эсрэг босогч алив бардамналыг устгаж, бодол бүрийг Христийн дуулгаварт олзолдог.” “Бодол бүрийг” гэдгийг

өөрөөр “гаргалгаа бүрийг” гэж орлуулж уншиж болох. Тулаан нь оюун санааны талбар юм: гаргалгаа, төсөөлөл, бодол, мэдлэг. Хүнийг цаазласнаараа хандлагыг нь өөрчлөхгүй. Тэрбээр хандлагаа өөрчлөхгүй.

Зүүн Африк дахь Мау Маугийн дэглэмийн үеэр Британийн эрх баригчид Мау Маугийн зарим удирдагч нарыг дүүжилж цаазласан байдаг. Миний танил нэгэн илгээлтийн эзэн тэр цаазыг гэрчлэн харсан юм. Тэд дүүжлүүр рүү явж байхдаа “Би буцаж ирнэ. Би буцаж ирнэ” хэмээн үглэсээр явсныг тэр илгээлтийн эзэн ярьж билээ. Тэр үгийг хүн хэлсэн биш, харин хүний доторх чөтгөр хэлж байжээ. Хүний биеийг устгаж болох ч, хүний доторх чөтгөр буцаад л ирнэ.

Бид махан бие, цусан бодтой дайтаагүй. Бидний төлөвлөгөө өөр: дайсан өөр, зэвсэг өөр. Бурханы бидэнд өгсөн зэвсэг хүчирхэг болой! Хэрэглэж чадах аваас, тэдгээр нь дийлдэшгүй хүчтэй зэвсэг юм. Бид ялагдсан бол, хуяг дуулга, зэр зэвсэг дутагдснаас болоогүй, харин үүнийгээ хэрэглэж чадаагүйгээс л болжээ.

Хуучин гэрээний жишээ

Би танд хүн төрөлхтний хэрэг явдлыг захиран, хянаж байдаг тэр үл үзэгдэх, сүнсний талбарыг харуулах хөшгийг ярах, Хуучин гэрээний хоёр жишээг харуулмаар байна. Дэлхийн хэрэг явдал, улс үндэстний хэрэг явдал, хувь хүний хэрэг явдалд сүнсний хүчин зүйлс шийдвэрлэх үүрэгтэй гэдэгт би итгэдэг. Бид түүхэн үйл явдлын үнэнийг, үүний нийгмийн болоод эдийн засгийн хүчин зүйлст нөлөөлөх нөлөөг нь хүлээн зөвшөөрөх ёстой. Тэдгээр нь бодитой хүчин зүйлс боловч, тэдгээрийн цаана орших ноёлогч бөгөөд шийдвэрлэх бүтэц нь сүнсний хүчин зүйлс байдаг. Тиймээс л чуулган нь дэлхийн хэрэг явдлын шийдвэрлэх хүчин зүйл болдог. Учир нь энэ талбарт нэвтэрч, ажиллаж чаддаг цорын ганц төлөөлөгч нь чуулган билээ. Маш тодорхой байна.

Езекиел 28-аар бүлэг “хүнээр захируулдаг ил хаанчлал, сатанаар захируулдаг далд хаанчлал” гэсэн давхар хаанчлалыг маш тодорхой илчилдэг. Тус бүлгийн эхний

арван есөн эшлэл дээр хоёр хүний талаарх гашуудал, халаглал үгс байна. Нэгийг нь “Тирийн ханхүү” гэсэн бол, нөгөөг нь “Тирийн хаан” гэжээ. Тирийн ханхүү нь хүн. Тэрбээр өөрийгөө Бурханаар өргөмжлөв ч, үнэндээ үхэх тавилантай хүн билээ. Тэгвэл Тирийн хаан нь хэзээ ч хүн байгаагүй, хэзээ ч хүн байхгүй. 12-18-аар эшлэл дээрх шинж тэмдгийг нь ажиглабаас, ганц л дүгнэлтэнд хүрэхээр байна: Тирийн хаан нь Сатан өөрөө ажээ. Ханхүүгээр захируулсан, ил Тирийн хаанчлалын цаана харанхуй дэлхийн захирагч Сатанаар захируулсан далд Тирийн хаанчлал оршин байжээ. Далд хаанчлалын хэрэг явдал нь ил хаанчлалын хэрэг явдлыг шийдвэрлэжээ. Тэгэхээр далд зүйлс л шийдвэрлэх хүчин болж байна.

Хаанчлал, үндэстэн, том хот болгоны ард далд захиргаа оршдог гэж би итгэдэг. Флорида мужийг захирдаг захиргаа бий, Майамиг захирдаг сүнсний далд хүчин бий. Би газар сайгүй аялсан хүн учраас, хот бүр өөрийн гэсэн онцгой сүнсний уур амьсгалтай байдгийг хэлнэ. Хэдэн жилийн

өмнө Берлинд очтол бэлгийн цэвэр бус байдал, тачаалын уур амьсгал давамгайлж байлаа. Хот бүр өөр, өөрийн гэсэн нөлөөлөлтэй. Чикагод хүчирхийллийн сүнс ноёлдог. Шинэ Орлеанд илбэ шид. Мэдрэг хандах аваас ноёрхогч, хянагч далд сүнсний хүч мэдрэгддэг. Эдгээр сүнсний хүчийг залбирлаар захиргаандаа оруулахаас нааш Бурханы хаанчлалд сэргэлт ирэхгүй. Харин оруулж чадбал, үндэстэн, хаанчлал, хотод сэргэлт үерлэн бууна. Далд талбар л Бурханы жинхэнэ үйл хөдлөлд саад учруулдаг.

Үүнийг хэдэн жилийн өмнө Аргентинд өрнөсөн үйл явдал тодорхой харуулна. Миллер гэдэг нэгэн илгээлтийн эзэн Бурханы ажлыг хийх зүйл бүрийн төлөвлөгөө өвөрлөсөөр Аргентинд очжээ. Гэтэл Бурхан түүнийг хөдөөгийн нэгэн жижиг чуулганд сарын турш хорьчихсон болохоор, тэрбээр залбирахаас өөр юу ч хийж чадсангүй. Тэрбээр Аргентин улсыг захирагч сүнсний хүчнүүдийг захиргаандаа оруулах хүртэл залбирчээ. Хэний ч мэдэхгүй тэр Америк номлогчийн эзэлгээгээр Бурхан

гайхамшгаа үйлдэн, “улаан” Ромын католик тэр улсын хамгийн том цэнгэлдэх хүрээлэнгийн үүдийг тайлжээ. Сарын дараа гэхэд Америк номлогчийн үгийг сонсохоор өдөр бүр 200,000 хүн цугладаг болов. Энэ бол чуулганы түүхэнд тэмдэглэгдэж үлдсэн Бурханы онцгой үйлсийн нэг бөгөөд далд сүнсний хүчийг хүлсний үр дүн байсан юм.

Хуучин гэрээний нөгөө жишээ нь Даниел 10-аар бүлэг дээрх сүнсний хүчний жишээ болно. Даниел ард түмнийхээ төлөө Бурханы онцгой оролцоог хүсэн 21 өдөр залбирчээ. Энэ хугацааны төгсгөлд тэнгэрэлч Даниелд “залбирлын чинь хариулт ирсэн” гэдэг илчлэлийг хүргэж ирсэн байна: “Бурханыхаа өмнө өөрийгөө дорд болгохоор зүрх гаргасан анхны өдрөөс чиний үгсийг Бурхан сонссон учир би үгсийн чинь улмаас ирлээ” (Даниел 10:12). Даниел 21 өдөр залбирсан атал залбирал нь анхныхаа өдөр л Бурханы сонорт хүрсэн байжээ. Тэгээд ямар учраас 21 өдөр хүлээв? 13-аар эшлэл дээр тэнгэрэлч учрыг нь тайлжээ: “Гэвч Персийн хаант улсын жонон намайг хорин

нэгэн өдөр эсэргүүцсэн. Харин тэргүүн жононгуудын нэг, Михаел надад туслахаар ирэв.” Тэр “Персийн ханхүү” нь хүн биш ажээ. Энэ бүх үйл явдал хүний газар дээр өрнөөгүй. Мэдээг тэнгэрэлч авчирсан, түүнд өөр тэнгэрэлч саад хийсэн. Тэгтэл мэдээ хүргэгч тэнгэрэлчид Михаел хэмээх өөр нэгэн тэнгэрэлч туслахаар ирсэн. Энэ бүхэн нь тэнгэрст өрнөсөн тэнгэрэлч нарын тулаан байжээ.

Тэгэхээр, газар дээр өрнөсөн үйл явдал тэнгэрийн үйл явдлыг шийдвэрлэсэн байгааг тэмдэглээрэй. Энэ бол алмайруулмаар үнэн. Даниелийг залбирахаас өмнө юу ч болоогүй байсан. Даниелийн залбирал тэнгэрэлч нарыг хөдөлгөснөөс биш, тэнгэрэлч нар Даниелийг хөдөлгөөгүй. Бурханы хүмүүс бид асуудлыг шийдвэрлэдэг хүмүүс болохоо ухаардагсан бол, сайхан аа. Үүнийг тэнгэрэлч нар биш, бид хийнэ!

Илчлэл 12:11 дээр “Тэд” - газар дээрх Бурханы хүмүүс “...түүнийг” - Саганыг - “...Хурганы цус, өөрсдийн гэрчлэлийн үгээр ялжээ” гэдэг. Ертөнцийн хэрэг явдалд

бид л шийдвэрлэх хүчин зүйл болдог. Би хөөргөдөөгүй шүү. Даниел залбираагүй бол, юу ч болохгүй байх байв. Тэрбээр хариулт авах гэж 21 өдөр залбирсан. Хариулт ирэхэд юу саад хийсэн? Даниел Бурханы хүслийн дагуу залбираагүй учраас, залбирал саатсан юм биш. Түүний залбиралд ямар ч асуудал байгаагүй. Энэ саатлын эзэн нь Персийн хаанчлалын ханхүүгийн доторх Сатан л байжээ.

Бид ч бас буруу залбирсан учраас бус, харин муу ёрын, хуучин ханхүүг зайлуулах ёстой учраас, залбирлын маань хариулт саатах тохиолдол олонтаа. Үүнийг хийхэд бэлэн биш бол, та залбирлынхаа хариултыг авахгүй. Та ялан ялтлаа залбирах ёстой. Сатантай халз тулах ёстой. Олон хүн ингэхээс айдаг. Энэ талбар руу орбол, дундаж итгэгч хүнд тэр бүр нүүрлээд байдаггүй асуудал, өдөөлт ирнэ. Далд хүчнүүд эрх баригчдынхаа төлөө эрүүл ухаантайгаар залбирахаар шулуудсан хүн рүү шууд дайрна. Тиймээс энэ бүхэнтэй халз тулах эр зориг, эрүүл ухаан байхгүй бол, эхлүүлэх ч хэрэггүй. Хатуу үг байж магадгүй ээ. Гэхдээ үнэн нь л тэр.

Тэнгэрэлч илчлэлээ хүргэж ирснийхээ дараа 20-аар эшлэл дээр: “Би чам уруу юуны тулд ирснийг чи ойлгож байна уу? Гэвч би одоо Персийн жононтой байлдахаар буцах ёстой. Тиймээс би явлаа. Харин харагтун, Грекийн жонон ирэх гэж байна” гэжээ. Эдгээрийн хэн нь ч хүн биш ажээ. Эдгээр нь газрын хаанчлалын ард байх сатаны захирагч нар юм. Эдгээр хаанчлал нь Ариун газрыг ар араасаа ээлжлэн захирсан гэдэг утгаараа онцгойрдог. Эхлээд Вавилон тэгээд Перс, дараа нь Грек, эцэст нь Ром. Хаанчлал бүрийн ард сатаны том ханхүү оршиж байв. Энэ бүх үйл явдлыг тэнгэр шийдээгүй, харин газар дээр залбирсан Даниел гэдэг хүний залбирал шийджээ.

Езекиел 22:30-31 дээр Бурхан: “Би үүнийг устгахгүйн тулд энэ нутгийн төлөө Миний өмнө цоорхойд зогсож, хэрмийг барих хүнийг дундаас нь хайсан боловч ганцыг ч олсонгүй.

Тийнхүү Би дээрээс нь зэвүүцлээ асгалаа. Би уурынхаа галаар тэднийг шатаалаа. Тэдний явдлыг Би толгой дээр нь хариу

болгон буулгав” гэжээ. Бурхан “Бүхэл бүтэн үндэстэн дундаас ганц хүнийг олсон бол, тэднийг өршөөх байлаа” гэжээ. Бодоод үз! *Ганцхан хүн* үндэстнийг чиглэсэн түрлэгийг эргүүлэх байж. Гэтэл үүнийг хийх хүсэлтэй хүн нэг ч байгаагүй.

Бурхан хүнийг хайдаг! Хүнийг гэдэг нь эр хүнийг хэлж байгаа юм шүү. Христэд итгэдэг эрчүүд эр хүн шиг амьдрах цаг нь болжээ. Удирдлага анхнаасаа хатагтай нарын гарт таарах зүйл байгаагүй. Би эмэгтэйчүүдийг шүүмжлээгүй, харин эрчүүдийн алдааг зааж байна. Монгол эрчүүд нөхөр, аав, сүнсний удирдагч байх гурван үүрэг хариуцлагаа хөсөрдүүлсэн. Бурхан *цоорхойд зогсож, хэрмийг барих ганц хүнийг* хайж байна. Олохгүй бол, Хуучин гэрээний Израильчуудад тохиолдсон шиг л юм болно. Бүх зүйл танаас хамаарна! Үүнийг ойлгохгүй байгаа бол, Бурхан таны нүдийг нээх болтугай. Хувийн үүрэг хариуцлагаа хүлээхгүй байгаа бол, Бурхан танд гэмшихэд туслах болтугай.

Дерек Принсийн өв сургаалын цахим санд тавтай морилно уу!

Дерек Принсийн өв сургаалын цахим сан нь Араб (237 сая), Хятад (1,597 сая), Фарси (57 сая), Франц (75 сая), Хинди (260 сая), Индонезийн Бахаса (200 сая), Япон (122 сая), Монгол (6 сая), Румын (24 сая), Орос (167 сая), Испани (414 сая), Тамил (69 сая), Үрдү (200 сая) гээд 13 үндэстэний хэлээр 3,4 тэрбум хүнд хүрэхээр ажиллаж байна. Манай гариг дээр амьдарч байгаа нийт хүн амын 50 орчим хувьд энэхүү өв сургаалын цахим сан хүрэх зорилготой юм. Эдгээр хэлүүдээс хамгийн эхэнд зорилтот үндэстэнд хүрч байгаа нь Монгол хэл дээрх өв сургаалын цахим сан билээ. Та доорх цахим хуудсаар түүний шилмэл 30 сургаалыг Монгол хэлээр үзэх боломжтой.

www.DerekPrince.mn

Дерек Принс



Хорьдугаар зууны босго давснаас хойшхи Бурханы ажил үйлсийн талаар эргэцүүлэн бодвол, ирээдүйтэй мөнхөд салшгүй холбогдох нэгэн нэр бол Дерек Принс гэдэг нэр. Эгэл даруу боловч дэлхийн энтэй Библийн эрдэмтэн. Бурханд өргөсөн бүрэн үнэнч зориулалт, Ариун Сүнсэнд дуулгавартай зан байдал нь түүнийг цаг үеийнхээ олноо хамгийн ихээр хайрлуулж хүндлүүлсэн Библийн багш болгожээ.

Дерек Принсийн амьдрал өөрчлөгч Библийн сургаал нь нэгэн жарны турш даян дэлхийн

сая сая итгэгч хүний амьдралыг өөрчлөх эх суваг болсоор байна. Дерек Принс 1915 онд Энэтхэгийн Банглорт Британий цэргийн даргын гэр бүлд мэндэлжээ. Тэрбээр арван дөрвөн насандаа Етон коллежид, харин хожим Кэмбрижийн их сургуульд тэтгэлгээр шалгаран суралцжээ. Дерек Принс онцсайн сурлагаараа тэргүүлж, Кэмбрижийн кингс коллеж дахь Эртний бөгөөд Орчин цагийн философийн хүндэт гишүүнээр сонгогдсон нь түүхнээ ийнхүү сонгогдсон хамгийн залуу хүн болсон юм.

Гэтэл Дэлхийн Хоёрдугаар Дайн дэгдсэнээр Дерек Принсийн эрдмийн ажлыг таслан зогсоожээ. 1940 онд тэрбээр философийнхоо итгэл үнэмшлээр байлдааны ангид биш, Хааны цэргийн эмнэлэгт алба хаах үүргийг сонгов. Хэдийгээр тухайн үед Дерек “Надад шашин нэг их нэмэр болдоггүй” гэж хэлдэг байсан ч, Библийг гүн ухааны бүтээл гэдэг утгаар нь чөлөө заваараа үзэхээр авч явжээ. Анхандаа тэрбээр Библийг огтхон ч ойлгосонгүй.

Тийм боловч үргэлжлүүлэн уншаар байсан бөгөөд 1941 оны долдугаар сарын нэгэн өдөр Иогша дахь цэргийн ангийнх нь өрөөнд Бурхан Дерекийн нүдийг нээжээ. Тэр өдөр Бурхан Дерек Принст насан турш мөнхөрсөн амин чухал

хоёр үнэнийг ойлгуулжээ. Энэ ер бусын үйл явдлынхаа талаар Дерек Принс өөрөө ийнхүү өгүүлсэн буй: “Би Бичээсээр буюу Библиэр дамжуулан айлдаж буй Есүсийн дуу хоолойг дэндүү тод сонссон. Түүний дуу хоолойг сонссон тэр өдрөөс өнөөг хүртэл би хоёр зүйлд нэг ч эргэлзээгүй юм. Би Есүсийг амьд гэдэгт хэзээ ч эргэлзээгүй. Би Библи бол Бурханы үг гэдэгт хэзээ ч эргэлзээгүй.”

Есүстэй уулзсан энэ хүчирхэг уулзалтынхаа дараах нь Дерек Принс Хойд Африк руу шилжсэн бөгөөд Египет, Ливи, Суданы цөлд цэргийн эмнэлэгт алба хаахдаа, Бурханы Үгд шамдан суралцаар байлаа. Дайны дараа тэрбээр Иерусалимд цэргээс халагдаж, Данийн илгээлтийн эзэн Лидиа Кристенсентэй гэрлэхдээ, Лидиагийн өргөж авсан найман охины аав болжээ.

Дерек, Лидиа хоёр 1948 онд Израилийг тусгаар тогтнолоо тунхаглах хүртэл Иерусалимд амьдрахдаа зүрхэндээ Бурханы хүмүүс болох Израилийн хүүхдүүдийн төлөө үйлчилж бас залбирах дуудлагыг хүлээн авчээ. Тэрбээр энэ дуудлагаа үй олон хүнд өвлүүлсэн билээ. 1948 оны адгаар буюу дөнгөж шинээр мэндэлсэн Израиль хөлөө олох гэж зүдэрч байсан тэр

цагт Дерекийн гэр бүл Иерусалимаас Англи руу нүүж, Дерек төв Лондонгийн нэгэн жижиг Пентекост чуулганы пастор болжээ.

Дерек Лондонд, дараа нь Кенид тэгээд Америкт үйлчлэхдээ итгэгч хүмүүсийн амьдралын дийлэнх юмс байх ёстой эсвэл байж болох хэм хэмжээ, хэвдээ байхгүй байгааг олж харжээ. Тэрбээр дийлэнх итгэгчид өдөр тутмын амьдралын асуудал бэрхшээл дор нухлагдан, амь тэмцэж явдгийг харсан байна. Тиймээс үйлчилж байсан хүмүүсээ Библи уншлага болоод залбирлаар дамжуулан Бурханд ойртох хэрэгтэй хэмээн байнга урамшуулдаг байв.

1960 оны эхээр Дерекийг Вашингтон мужийн Сиэтл хотод пастораар үйлчилж байхдаа нэг өдөр түүнийг яг индрийнхээ ард номлож байхад нь чөтгөр түүнийг халз тулаанд дуудсан явдал Дерек Принсийг чөлөөлөлтийн үйлчлэлд хүчлэн оруулжээ. Цаг хугацаа өнгөрөх тусам, Дерек Принсийн Бичээсийг тайлсан номлолыг сонсож, Бурханы хүчийг хүлээж авахыг хүссэн хүний тоо өсөн нэмэгдсээр, тэдний тасралтгүй өсөх хэрэгцээг хангах үүднээс аудио, видео кассет болоод номууд эрхлэн гаргасан явдал нь 1971 онд Флоридагийн Форт - Лаудердэйлд байгуулагдсан “Дерек Принс пабликэйшн” - ий суурь болжээ.

Дерекийн анхны гэргий Лида түүнтэй 30 гаруй жил үр жимс, үйлчлэлээр дүүрэн ханилаад, 1975 онд өөд болов. Энэ хагацал нь Дерект асар хүнд туссан боловч, тэрбээр урьд урьдынхаасаа ч илүү аялж номлосоор байлаа. Хэдэн жилийн дараа Дерек Иерусалимд байхдаа, нуруугаа асар хүнд гэмтээсэн Рүүт Бэйкер гэдэг эмэгтэйн төлөө залбирчээ.

Гэтэл цаг хугацаа хөврөх явцад Эзэн Дерект түүний сайн мэдэхгүй тэр бүсгүйтэй гэрлэхийг нь илчилж өгчээ. Нилээд залбирч, нягталсны эцэст 1978 онд Дерек, Рүүт хоёр гэрлэсэн бөгөөд Эзэн тэдний өмнө үйлчлэлийн цоо шинэ хуудсыг нээжээ. Энэ шинэ үйлчлэлийн хуудас нь “Дерек Принстэй хамт өнөөдөр” нэртэй өдөр тутмын радио нэвтрүүлгээр эхлэсэн бөгөөд тэд анх Америкт 8 станцтай байв. Тэднийг радио үйлчлэлээ эхлүүлэх үед Эзэн тэдэнд: “Бичээсийн гол суурь үнэнийг хүмүүст амархан, товч, тодорхой ойлгогдохоор тунхагла!” гэж хэлжээ.

Өнөөдөр Dereкийн радио нэвтрүүлэг болоод ном, интернет төвтэй мэдээллийн эх үүсвэр нь 100 гаруй хэл дээр даян дэлхийн сая сая итгэгчдэд хүрч байна. Dereкийн сургаалын эрэлт хэрэгцээ зогсоо зайгүй өсөн нэмэгдэж байсан бөгөөд Дерек, Рүүт хоёр ч дэлхий даяар

аялан үйлчилсээр байлаа. 1998 оны 12-аар сард Рүүт таалал төгсөв.

2003 оны намар Дерек Принс хорь гаруй жил гэрээ болгосон хайртай Иерусалим хотдоо 88 насандаа таалал төгссөн юм. Тэрбээр бидэнд гайхамшигтай өв үлдээгээд явсан. Түүнийг мэддэг хүмүүст Дерек Принс Бурханд яаж захирагдах, чуулганыг яаж хайрлахыг болоод Израилийн төлөөх зүрх сэтгэл... түүнчлэн Бурханы хүмүүс өөрсдийнх нь төлөө Христийн худалдаж авч өгсөн эрх чөлөө дотор бүрэн дүүрэн амьдрахыг харах гал халуун хүсэл тэмүүллийн жинхэнэ, амьд үлгэр жишээ болсон юм.

Үүнээс гадна ном, нийтлэл, номлол, захидал, аудио болоод видео хичээлээрээ Библийн гэгээрлийн үнэлэшгүй эрдэнийн санг үлдээсэн билээ. Дерек Принс тавь гаруй ном, 600 аудио, 100 гаруй видео хичээлийн зохиогч бөгөөд ихэнх нь дэлхийн 100 гаруй хэлээр орчуулагдаад байна. Тэрбээр удмын хараал, Израильд хандсан Библийн үнэн ач холбогдол, чөтгөрийн онол тэргүүтэй хэний ч зааж байгаагүй сэдвээр заасан анхны хүн.

2002 онд Дерек Принс “Эзэн надаар дамжуулан жар гаруй жилийн тэртээс эхлүүлсэн энэ үйлчлэл Есүсийг эргэж ирэх хүртэл амьдрах

нь миний болоод Эзэний ч чин хүсэл мөн гэдэгт би итгэж байна” гэж хэлжээ. Өнөөдөр Дерек Принсийн үйлчлэл “сүнсний цангаатай” тэмцсээр, 140 гаруй улсын чуулганы удирдагч нар, библийн сургуулийн төгсөгчид, сая сая жирийн итгэгчдийг амьдрал өөрчлөх Библийн сургаалаар хангасаар, Есүсийг эргэж ирэх хүртэл хүлээсэн даалгавраа биелүүлсээр явна.

Энэхүү үйлчлэл нь дэлхийн 45 орчим оронд байршдаг, Дерек Принсийн үйлчлэлийн төлөөлөгчийн газраар дамжин хийгддэг бөгөөд үүнд Австрали, Канад, Хятад, Франц, Герман, Нидерланд, Шинэ Зеланд, Норвеги, Орос, Өмнөд Африк, Швецарь, Их Британи болоод Америк улс дахь гол гол төлөөлөгчийн газар зүй ёсоор багтана. 1941 онд буюу Дерекийг итгээд удаагүй байхад Бурхан Дерект нэгэн үг өгсөн бөгөөд тэр цагаас хойш Бурхан амласан үгийнхээ дагуу Дерекээр дамжуулан гайхамшигтай үйлс хийжээ.

Бурхан Дерект: “Энэ нь эхлээд бяцхан горхи шиг байна, бяцхан горхи нь гол болно, гол нь мөрөн болно, мөрөн нь тэнгис болно, далай нь хүчирхэг далай болно. Би үүнийг чамаар дамжуулан үйлдэх боловч, хэрхэн гэдгийг нь чи мэдэхгүй, мэдэж чадах ч үгүй, мэдэх ч ёсгүй” хэмээн айлджээ.

Өнөөдөр ч даян дэлхийн сая сая итгэгчид амьдрал өөрчлөх сүнслэг үнэнээр цангасаар байна. Энэ алсын харааг бүрэн биелэл болгох нь Дерек Принсийн үйлчлэлийн гол зорилго билээ

Дерек Принсийн номууд

Монгол хэлээр

1. ХРИСТЭД ИТГЭХ ИТГЭЛИЙН АМЬДРАЛЫН СУУРЬ ҮНЭН: Тэнцвэртэй бөгөөд Сүнсээр дүүрэн амьдрахын төлөө мэдэх шаардлагатай үнэн

2. ЕРӨӨЛ ЭСВЭЛ ХАРААЛ: СОНГОЛТ НЬ ТАНЫХ! Хүлцэж амьдарсан дарамтын хүлээсийг тасар татан чөлөөлөгдөхүй

3. ТЭД ЧӨТГӨРИЙГ ХӨӨНӨ: Үл үзэгдэгч дайсан - чөтгөрийн талаар мэдэх ёстой үнэн

4. ЭР НӨХӨР БӨГӨӨД ААВ: Эр хүнд зориулсан Бүтээгчийн зорилгыг сэргээн танихуй

5. ТА БУРХАНД ҮНЭ ЦЭНЭТЭЙ: Бүтээгчийн мэлмий дэхь үнэ цэнээ танин мэдэхүй

6. ЭЗЛЭХЭЭР ДУУДАГДСАН: Тэнгэрийн хаанчлал дахь үүрэг даалгавраа олохуй

7. ТАНЫ ХЭЛ ЯРИАНД ЭДГЭРЭЛ ХЭРЭГТЭЙ ЮУ?

8. ДЭЛХИЙН ТӨГСГӨЛ - БИБЛИЙН ЗӨГНӨЛ

9. ТАНЫ ДОТОР ОРШИХ АРИУН СҮНС

10. БУРХАНЫ АНАГААГЧ ЭМ


11. СҮНСНИЙ ТУЛААН

12. ТЭНГЭРЛЭГ СОЛИЛЦОО (Товч хувилбар)

13. СОЛИЛЦОО

14. ТӨР ЗАСГИЙНХАА ТӨЛӨӨ ЗАЛБИРАХУЙ

15. ХАРААЛААС ЕРӨӨЛ РҮҮ (Товч хувилбар)



Та дээрх номуудыг ухаалаг утас дээрээ

#ГэрэлтApp-аар

СОНСОХ ХУВИЛБАРААР

худалдан авах боломжтой!

*Мараната YouTube
сүвгаас үнэ төлбөргүйгээр Дерек
Принсийн видео хичээл, сонсдог номыг
сонсох боломжтой.*



Maranata Resource and Training Center

2.69K subscribers

SUBSCRIBED



HOME

VIDEOS

PLAYLISTS

COMMUNITY

CHANNELS

ABOUT



Uploads PLAY ALL

≡ SORT BY



Дерек Принс: Та Бурханд үнэ цэнэтэй. Бүтээгчийн...
2.1K views • 2 weeks ago



ДЕРЕК ПРИНС: Эр нөхөр бөгөөд аав (Төгсгөлийн...
1K views • 3 weeks ago



ДЕРЕК ПРИНС: Эр нөхөр бөгөөд аав (Эхний хэсэг) |...
1.7K views • 3 weeks ago



Дерек Принс: Итгэлийн СУУРЬ ҮНЭН номын 49-р...
332 views • 2 months ago



Дерек Принс: Итгэлийн СУУРЬ ҮНЭН номын 52-р...
330 views • 2 months ago

www.DerekPrince.mn